




2025 02-р сар

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ АЛБА

ИНФЛЯЦ 2025 ОНЫ 1-Р САРЫН БАЙДЛААР 9.6%-ТАЙ ГАРЧ ҮРГЭЛЖЛЭН ЭРЧИМЖСЭЭР БАЙНА.

- Инфляц 2025 онд төсвийн тэлэлт болон импортын барааны үнийн өсөлтийн нөлөөгөөр үргэлжлэн эрчимжих төлөвтэй байгаа ба Монголбанкны зүгээс мөнгөний хатуу бодлого баримталж бодлогын хүүг өсгөх хүлээлттэй байна.
- Бараа, үйлчилгээний бүрэлдэхүүн үзүүлэлтийн хувьд орон сууц, ус, цахилгааны үнийн өсөлт өмнөх жилтэй харьцуулахад 22.4%-аар өссөн ба инфляцын өсөлтийн 2 нэгж хувийг эзэлж байгаа бол импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт 2.9 нэгж хувийг бүрдүүлжээ.
- 2025 оны 1-р сараас цалин, тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлж, мөн Эрдэнэс Таван Толгойн ногдол ашиг тарааж байгаатай холбоотойгоор дотоод эрэлт эрчимжиж байгаа бол, олон улсын нөхцөл байдалд тарифын бодлогын үр дүнд импортоор орж ирж буй бараа бүтээгдэхүүний үнийн дарамт нэмэгдэж байна.

НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН ОРЛОГО 449 САЯ АМ.ДОЛЛАРТ ХҮРСЭН БА ЭНЭ НЬ ӨМНӨХ ЖИЛТЭЙ ХАРЬЦУУЛАХАД 44 ХУВИАР БУУРСАН ҮЗҮҮЛЭЛТ БОЛЛОО.

- Гадаад худалдааны тэнцэл 46 сая ам.долларын ашигтай гарсан ба нийт экспортын өсөлт 23 хувиар буурч, нийт импорт 4 хувиар өссөн байна.
- Нийт экспортын орлогын 44.1 хувийг чулуун нүүрсний орлого бүрдүүлж байгаа бол 25.9 хувь буюу 264 сая ам.долларыг зэс, 7 хувь буюу 71 сая ам.долларыг алтны экспортын орлого бүрдүүлжээ.
- Нийт экспортын бууралт нь нүүрсний хилийн үнэ болон биет хэмжээ тогтмол буурч байгаатай холбоотой ба 2024 оны 1-р сард нүүрсний хилийн үнэ 122 ам.доллартой тэнцэж байсан бол 2025 оны 1-р сард 86 ам.доллар болж 41 хувиар буурчээ.
- Нийт импорт 973 сая ам.долларт хүрсэн ба дийлэнх хувийг нефтийн бүтээгдэхүүн, мөн суудлын болон ачааны автомашинууд бүрдүүлж байна. Дотоод эдийн засгийн идэвхжил өндөр байхын хэрээр импортын өсөлт эрчимжиж төлбөрийн тэнцэл алдагдалтай гарч, цаашлаад төгрөгийн ханш сулрах эрсдэлийг дагуулж байна.

УЛСЫН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ 493 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛТАЙ ГАРЛАА.

- 2025 онд төсвийн зардал 33.5 их наяд төгрөгт хүрэхээр тооцоолсон ба энэхүү дүн нь 2024 онтой харьцуулахад 3 их наядаар өсгөсөн төсвийн зардлын дүн юм. Мөн өмнө жилийн 12 сард засгийн газар төсвийн тодотгол хийж 2025 оны төсвийн тэнцлийг алдагдалгүй баталсан хэдий ч 2025 оны 1-р сард төсвийн орлого 1.6 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх жилээс даруй 39 хувиар буурсан үзүүлэлт болоод байна. Ийнхүү орлого буурсны үр дүнд төсвийн тэнцэл алдагдалтай гарлаа.
- Төсвийн зардал 2.1 их наяд төгрөгт хүрч өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 5.2 хувиар нэмэгдсэн. Үүний 86 хувь буюу 1.8 их наяд төгрөгийг урсгал зардал эзэлж байгаа бол 14 хувийг хөрөнгийн зардал, 0.28 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл бүрдүүлж байна.

ОЮУ ТОЛГОЙН ГҮНИЙ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ ДАХЬ ЗЭС, АЛТНЫ АГУУЛАМЖ НЭМЭГДСЭНЭЭР УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ГУРАВНЫ НЭГИЙГ БҮРДҮҮЛНЭ.

- Сангийн Яам 2025 онд эдийн засгийг өсөлтийг голчлон дэмжихэд зэс болон алтны олборлолт чухал үүрэгтэйг дурдлаа. Мөн нүүрсний экспортын биет хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Гашуун Сухайт, Шивээ Хүрэнгийн боомтоос гадна Замын-Үүд Эрээний боомтыг нэмж хүчин чадлаа нэмэгдүүлэхээр ажиллаж байна.
- ХАА-н салбарын өсөлт 2024 онд 3.6 хувиар буурсан бол энэ жил өвөлжилт, хаваржилт хэвийн үргэлжлэх нөхцөлд ХАА салбар сэргэж, дагаад боловсруулах үйлдвэрлэлүүд нэмэгдэх хүлээлттэй байна.
- Монголбанк, Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банк зэрэг байгууллагууд 2025 оны Монгол улсын эдийн засгийг дунджаар 6% байна гэж төсөөллөө.


ХУРААНГУЙ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД						
			2024Q4	2024Q3	2023Q4	
Бодит ДНБ	тэрбум төгрөг		32,054	22,829	30,567	4.9%
Ажилгүйдлийн түвшин	%		5.3%	6.1%	3.9%	35.9%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД						
			2025M01	2024M12	2024M01	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд						
Нийт экспорт	сая ам.доллар		1,019	15,783	1,325	-23.1%
Зэс	сая ам.доллар		264	3,319	220	20.0%
Нүүрс	сая ам.доллар		449	8,535	803	-44.1%
Нийт импорт	сая ам.доллар		973	11,612	936	4.0%
Хэрэглээ	сая ам.доллар		-344	-3,566	-304	13.2%
Түүхий эд	сая ам.доллар		-70	-933	-83	-15.7%
Хөрөнгө оруулалт	сая ам.доллар		-352	-4,955	-349	0.9%
Шатахуун	сая ам.доллар		-206	-2,162	-197	4.6%
Тэнцэл	сая ам.доллар		46	4,171	389	-749%
Дэлхийн түүхий эдийн үнэ						
Зэс	\$/тонн		8,976	8,910	8,351	7.4%
Нүүрс	\$/тонн		125	140	174	-28.1%
Газрын тос	\$/баррель		78	72	78	0.0%
Алт	\$/трой унц		2,707	2,641	2,034	33.0%
Улсын нэгдсэн төсөв						
Төсвийн тэнцэл	тэрбум төгрөг		-493	-776	677	-172.8%
Төсвийн орлого	тэрбум төгрөг		1,668	29,589	2,731	-38.9%
Төсвийн зардал	тэрбум төгрөг		-2,161	-30,365	-2,054	5.2%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД						
			2025M01	2024M12	2024M01	
Мөнгөний бодлого						
M2 нийлүүлэлт	тэрбум төгрөг		41,827	43,334	37,470	11.6%
ХҮИ (C2020)	индекс		154	152.2	140.5	9.6%
Бодлогын хүү	%		10.0%	10.0%	13.0%	-23.1%
Хүү ба ханш						
Ам долларын ханш (Эцсийн)	Төгрөг/\$		3,448	3,420	3,401	1.4%
Төгрөгийн хадгаламж	%		12.9%	12.9%	12.5%	3.1%
Валютын хадгаламж	%		4.1%	4.1%	3.9%	5.1%
Төгрөгийн зээл	%		17.3%	16.9%	17.1%	1.1%
Валютын зээл	%		11.2%	11.2%	11.6%	-3.9%
Гадаад валютын нөөц						
Нийт	сая ам.доллар		5,510	4,964	4,921	12.0%
Үнэт цаас	сая ам доллар		2,288	4,794	2,242	2.1%
Харилцах, хадгаламж	сая ам доллар		1,830	1,847	1,928	-5.1%
ОУВС-д байршуулсан хөрөнгө	сая ам доллар		7	7	7	0.0%
Зээлжих тусгай эрх	сая ам доллар		90	90	105	-14.3%
Мөнгөжсөн алт	сая ам доллар		669	618	566	18.2%

БОДИТ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

■ Бодит ДНБ-ий өсөлт (C2015)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛГҮЙДЭЛ БА ЦАЛИН




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Монголбанк

ДЭЛХИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ




Эх сурвалж: ОУВС

УЛСЫН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ГАДААД ӨР




Эх сурвалж: Монголбанк

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ




Эх сурвалж: Монголбанк

УЛСЫН ИНФЛЯЦ




Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ




Эх сурвалж: Монголбанк

АМ ДОЛЛАРЫН ХАНШ



Эх сурвалж: Монголбанк

БАНКУУДЫН ДУНДАЖ ХҮҮ



Эх сурвалж: Монголбанк



ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Анунжин

Цахим хаяг: anunjin.ba@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

О. Номуншүр

Цахим хаяг: nomunshur@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

С. Цацрал

Цахим хаяг: tsatsral.sa@golomtbank.com

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны алба нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.